



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/489

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулж, албан даалгаврын  
биелэлтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны "Арга хэмжээ авч ажиллах тухай" 11 дугаартай албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, усны нөөцийг бохирдож, хомсдохоос хамгаалах ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан 2022 оны 11 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангах, усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг сурталчлах, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд байгаа стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон, хаягдал усны нүхийг буулгах, устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, булах ажлыг орон нутагт зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны 5 дүгээр сарын 27-ны дугаар захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичиг:	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд:	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Ц.Гэрэлмаа	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Г.Билэгсайхан	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
	Б. Нандинцэцэг	Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Баяртогтох	Онон, Улз голын сав газрын захиргааны Дарга
	Б.Отгонсүрэн	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны дарга Сумдын Засаг дарга нар